



НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

03/150

2015 оны 04 сарын 07 өдөр

Дугаар НАГ-АХ/2015/-СА-I-1-09 Улаанбаатар хот

ТӨСВИЙН ОРЛОГО БОЛГОХ ТУХАЙ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Нийслэлийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ИТХ-ын 25 төлөөлөгч, ажлын албаны 18 ажилтан, нийт 43 хүнийг ОХУ-ын Улаан-Үд хотод ажиллуулахаар томилж, 27,774.0 мянган төгрөг гадаад томилолтын зардлаас гаргаж төсвийг үрэлгэн, үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн хуулийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 3.5 "гадаад албан томилолтын зардлыг бууруулах, зайлшгүй тохиолдолд зорчих төлөөлөгчийн тоог цөөлөх, ..." , 6 "улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ... гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 2.1.1.3 "Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал" заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг: Зориулалт бус, үрэлгэн зарцуулсан 27,774.0 мянган төгрөгийг холбогдох хүмүүсээр нь нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосугай.

Хоёр: Төлбөрийн 27,774.0 мянган төгрөгийг Нийслэлийн санхүү, төрийн сангийн хэлтсийн Төрийн сан банк дахь 200000955 тоот дансанд 2015 оны 9 дүгээр


сарын 25-ны дотор төлж барагдуулахыг Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Б.Бас-Оргил, нягтлан бодогч Г.Жавзандулам нарт хариуцуулсугай.

Дээрх төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2 "төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ." заалтыг хэрэгжүүлэх болно.

АКТЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН I АЛБАНЫ
I БАГИЙН АХЛАХ АУДИТОР
Д.ЖАРГАЛСАЙХАН
АУДИТОР



Г.ДОЛГОРСҮРЭН


ЗӨВШӨӨРСӨН:

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

НЯГТЛАН БОДОГЧ


Б.БАС-ОРГИЛ

Г.ЖАВЗАНДУЛАМ



ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА



Т.САРАНТУЯА

САНХҮҮГИЙН АУДИТЫН I
АЛБАНЫ МЕНЕЖЕР



Д.ЭНХДАЛАЙ



АУДИТЫН ҮР ӨГӨӨЖИЙН ТООЦООЛОЛ

1. **Аудитын код:** НАГ-АХ-/2015/СА-I-1-09
2. **Аудитын нэр:** Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

№	Аудитын үр өгөөжийн товч утга	Үр өгөөжийн нийт үнэлгээ (мян.төг)	Үр өгөөжийн хүртээмж		
			НАГ	Хан-Уул дүүргийн ИТХ	Төсвийн орлого болгох
1	Гадаад томилолтын зардлаас зориулалт бус зарцуулсан мөнгийг төсөвт төвлөрүүлснээр төсвийн орлого нэмэгдэж санхүүгийн сахилга бат сайжирна.	27,774.0	27,774.0		Төсвийн орлого болгох
НИЙТ ДҮН		27,774.0	27,774.0		


Харилцан тохиролцсоны үндсэн дээр санхүүгийн тайлангийн аудитын үр өгөөжийн дүн нийт 27,774.0 мянган төгрөг болохыг хүлээн зөвшөөрч, үр өгөөжийн 100 хувийг Нийслэлийн Аудитын газар бий болгосон гэж үзэв.

Аудитын үр өгөөжийг

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН I АЛБАНЫ
I БАГИЙН АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



ЗӨВШӨӨРСӨН:

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН

Д.ЖАРГАЛСАЙХАН БИЧГИЙН ДАРГА Б.БАС-ОРГИЛ

Г.ДОЛГОРСҮРЭН НЯГТЛАН БОДОГЧ Г.ЖАВЗАНДУЛА



ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН I АЛБАНЫ
АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ЭНХДАЛАЙ

ТӨЛБӨРИЙН АКТЫН НОТЛОХ ЗҮЙЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС 1

1. Төлбөрийн актын талаарх ерөнхий мэдээлэл


1	Аудитын нэр	Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
2	Аудитын код	НАГ-АХ-/2015/СА-I-1-09
3	Төлбөрийн актын дугаар	
4	Төлбөр хариуцагчийн овог нэр, албан тушаал	Нарийн бичгийн дарга Б.Бас-Оргил, Нягтлан бодогч Г.Жавзандаулам
5	Төлбөрийн мөнгөн дүн тоо, үсгээр	27,774.0 /Хорин долоон сая долоон зуун далан дөрвөн мянган төгрөг/
6	Төлбөрийн акт бичсэн он, сар, өдөр	2015 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр
7	Төлбөрийн акт тогтоосон ажилтны овог нэр, албан тушаал	Санхүүгийн аудитын I албаны I багийн аудитор Г.Долгорсүрэн

2. Төлбөрийн акт тогтоох үндэслэлийн талаарх мэдээлэл


Алдаа, зөрчлийн товч утга	1. 27,774.0 мянган төгрөгийн гадаад томилолтын зардал олгосон	
Зөрчигдсөн хууль тогтоомж, заавар, журам, гэрээ хэлцлийн	Нэр	Төсвийн тухай хууль, ЗГ-ын 147 тогтоол
	Зүйл, заалт	6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн хуулийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 3.5 "гадаад албан томилолтын зардлыг бууруулах, зайлшгүй тохиолдолд зорчих төлөөлөгчийн тоог цөөлөх, ..." , 6 "үлс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, үрлагийн наадам, үралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх

3. Төлбөрийн актын хууль эрх зүйн үндэслэлийн хяналт

03/150 дугаартай төрийн аудитын байгууллагын төлбөрийн акт тогтоох хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвшөөрсөн:


 Д.Жаргалсайхан
 /гарын үсэг/ /овог, нэр/


Дэд даргаас өгсөн чиглэл:

03/150 дугаартай төрийн аудитын байгууллагын төлбөрийн акт тогтоох хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж, зөвшөөрсөн:

 Т.Сарантуяа
 /гарын үсэг/ /овог, нэр/


4. Төлбөрийн акт тогтоох алдаа, зөрчлийг нотлох зүйлийн хяналт

03/150 дугаартай төрийн аудитын байгууллагын төлбөрийн акт тогтоох алдаа, зөрчлийг нотлох зүйлийн:
 хангалттай / үгээр бичих /
 найдвартай / үгээр бичих /
 хүчин төгөлдөр / үгээр бичих /
 үнэн зөв / үгээр бичих /

Болохыг хянасан:


 Д.Жаргалсайхан
 /гарын үсэг/ /овог, нэр/

Баталгаажуулсан:


 Д.Энхдалай
 /гарын үсэг/ /овог, нэр/

/огноо/